

Бага боловсролын “Хүн ба байгаль”-ийн бие даан суралцах ажлын дэвтрийн хариултын хуудас

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Биеийн сүүдэр ба нарын байрлал-1**


Анги: **5 дугаар анги**

Даалгавар	Хариултын мэдээлэл				Буруу хариултын шинжилгээ
1. Ойлгох	Зүг чигийг нарны байрлалтай холбож хэлэх нь нарны байрлалаар сүүдрийн уртыг тодорхойлоход хэрэглэгдэх учир нарын хөдөлгөөнтэй холбож ойлгох асуулт оруулсан болно.				
2. Ойлгох		А	Б	В	
	Ижил зүйл юу байна вэ?	Нар байна. Мод байна. Сүүдэр байна.			
	Юу өөрчлөгдсөн байна вэ?	Нарны байрлал, сүүдрийн хэмжээ, байрлал			
Нэмэлтээр тэнгэр, газар гэж бичих нь онц чухал ач холбогдолтой бус					
3. Хэрэглэх	Анхний модны сүүдэрт суухаар дэвсгэр тавилаа. Тэр үеийн нарыг будаарай. Нарны байрлалаа сүүдрийн уртыг тодорхойлох зорилготой. Тиймээс хамгийн богино гэж асуугаагүй учир нар зүүн талаас тусахад сүүдэр баруун талд тусна гэдэг ойлголтоор бүдэг шар хажуугийн 2 нарыг будсан байж болно. Модны доор гэж байгаа учир эгц дээрх нарыг будах чухал				
https://youtu.be/IQ_OqiPhSdU бичлэгээс нарны байрлалаас сүүдэр хэрхэн өөрчлөгдөж буй үзэх боломжтой.					

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Биеийн сүүдэр ба нарын байрлал-**




Анги: **5 дугаар анги**

1. Ойлгох	А.Нарны цаг ашиглан хэдэн цаг болж буйг мэдэх боломжтой. 10:00-12:00 цагийн хооронд сүүдрийн хэмжээ /богиносон, багассан эсвэл нар зүүнээс баруун тийш шилжих тутам, нар өндөрт хөөрөх тутам сүүдрийн хэмжээ багассан гэсэн утгуудыг тооцно/ Б. Нарны байрлал болон сүүдрийн туссан хэмжээ, байрлалыг зурагт үзүүлжээ. /Нар зүүн/ талд байхад /сүүдэр эсрэг эсвэл баруун талд байх/ ба нар өндөрт хөөрсөн эсэхээс шалтгаалан сүүдэр нь /урт богино/ байна.		
2. Хэрэглэх	 15:00, 12:00, 09:00 той 1 цагийн зөрүүтэй ойролцоо бичсэн байж болно. Учир нь баруун аймгууд цагийн зөрүүтэй байдаг. Мөн сурагч өөрөө туршилт хийгээд цагаа харсан үед баримжаагаар зүүн аймгуудад ч тэгж бичсэн байж болно. Цонх үлдээсэн учир өглөө, өдөр, орой гэж бичих зохимжгүй болов уу.		
3 Бүтээх	Монголчуудын уламжлалт цагийн баримжааг нарын тусгалаар мэддэг аргуудыг дурдах чухал. Гэрийн тооноор орсон нарын туяагаар, байшиндаа, гэр сургуульдаа нарын тусгалаар цагийн баримжааг тайлбарласан байвал		

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Өдөр шөнийн ялгаа-1**



Анги: **5 дугаар анги**

1. Хэрэглэх	1 “X” гэж тэмдэглэсэн хэсэгт өдөр шөнийн аль нь болж байгаа вэ?  Нарын тусгалыг эсрэг талд шөнө болж байдаг гэдгийг ойлгож хэрэглэнэ. Үүр цайж байна гэсэн хариулт нь асуултаад ойлгож уншаагүй гэсэн үг.	
2. Задлан шинжлэх	 Өгөгдсөн зургийг ашиглан хийж болно. Цаасан шувууг өдрийн цагт тоглоно гэж ойлгоно. Хэдийгээр харанхуйд салхитай үед нисгэж болох ч шөнө гэдэгт ангилсан тохиолдолд учрыг тодруулаарай. Сарыг өдөр харсан тохиолдол байж болно. Гэвч дараагийг агуулгад энэ тохиолдлыг гүнзгийрүүлж судлах тул сарыг өдөр гэж яагаад бичснийг тодруулж давхардсан хэсэгт ангилж болно.	
3. Бүтээх	Гадна талд цагийн зүүний эсрэг чиглэлийг зурсан байвал тооцно. 	

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Өдөр шөнийн ялгаа-2**

Анги: **5 дугаар анги**

1. Задлан шинжлэх	Нар, сар, дэлхийн хөдөлгөөнийг зургаар үзүүлжээ. Зураглалыг сайтар ажиглаад, цагийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй. 1 Дэлхийн тэнхлэгээ эргэх хөдөлгөөн  Дэлхий 24 цагт тэнхлэгээ бүтэн тойрч эргэх ба нарны туяа туссан талыг нь өдөр, нөгөө талыг нь шөнө гэнэ. 2 Дэлхий нарыг тойрох хөдөлгөөн  Дэлхий жилийн турш цагийн зүүний эсрэг нарыг тойрч эргэдэг учир өдөр, шөнө ба улирлууд ээлжилдэг. 3 Нар, сар, дэлхийн хөдөлгөөн  Сар дэлхийг тойрон эргэдэг. Дэлхий, сар хамтдаа нарыг тойрон эргэдэг. Зураглал, графикийг ойлгож унших, эргэцүүлэх, нэгтгэн дүгнэх чадвараа ашиглана.	
2. Үнэлэх	Өдөр шөнө яагаад солигддог вэ туршилтыг зааврын дагуу хэрэглэгдэхүүнээ бэлтгэж туршилт хийх явцдаа “Монголд өдөр болж байхад хаана шөнө болж буйг ажиглаж, тэмдэглэх” зэргээр дэлхийн хөдөлгөөнийг өөрсдөө туршсан аргаа бусадтай хуваалцана.	

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Сарны хэлбэр-1**

Анги: **5 дугаар анги**


1. Ойлгох	1 Гурван найз өглөө босоод урд зүгт уулын орой харж зогслоо. Тэд тэнгэрт нар, сар хамтдаа байхыг хараад таамаглан ярилцав. Та нарын таамаглалтай нийцэж байгаа дугаарыг дугуйлаарай. Өөрсдийн таамаглалыг нэмж бичиж болно.  1. Сар хагас талаараа л дэлхийд үзэгдэх хэлбэрээр тогтсон байдаг байх. 2. Сар тал харагдаж байгаа учир нарны туяатай холбоотой байх. 3. 4. Өмнөх өдөр ингэж харагдаагүй учир сарны байрлал өөрчлөгддөг байх. 5. Сарны байрлал өөрчлөгддөг эсэхийг нэг газраасаа тодорхой хугацааны дараа дахин дахин хараад мэдэх боломжтой байх. Туршиж үзье. Таамаглалуудаас дугуйлж болно. Сар нарны гэрлийг ойлгодог учир харагддаг гэж өндөр түвшинд таамаглах сурагч ч байж болно. Мэдлэг ойлголтыг илрүүлэх гэж байгаа учир хариулт зөв буруу байгааг багш тэмдэглэж аваарай. 1-р хариулт буруу ташаа ойлголт юм.	
2. Хэрэглэх	Зааврын дагуу туршилт хийж байж сарны хэлбэрийг ажиглах аргад суралцана. Уншиж ойлгох, ажиглах аргаа зөв эзэмших чухал.	
3. Задлан шинжлэх	 Энэхүү зургийг ажиглаад хүүхдүүдийн сарыг ажиглаж тэмдэглэсэн аргад дүгнэлт гаргах юм. Тиймд өндөр уулын оройтой харьцуулдаг, хотгор завсрын харалдаа харцуулдаг, шовх орой бүрийг нэрлээд аль нэгтэй харьцуулах боломжийг дурдсан бол зөв.	

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Сарны хэлбэр-2**

Анги: **5 дугаар анги**





1. Ойлгох	 Сарны хэлбэр дотроос бүтэн сарыг шууд харсан байж болно. Эсвэл дэлхийгээс сар руу харахад яаж харагдахыг эргэцүүлж болно.	
2. Хэрэглэх	15-ны сар бүтэн харагддаг учир тэргэл сар гэдгийг ойлгосон.	

3. Задлан шинжлэх	 Сарны харагдах хэлбэрийг нэрээр нь өгсөн байгаа бөгөөд адилхан тал сар боловч ялгаатай талыг эргэцүүлж, дүгнэнэ. Тойрог хөдөлгөөнтэй холбож эргэцүүлнэ.	
----------------------------------	--	--

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Сарны хэлбэр-3**

Анги: **5 дугаар анги**

1. Ойлгох	- Сарны хэлбэр өөрчлөгдөж байгаа шалтгаан нь юу, юу байж болох вэ? Нарны улаан туяатай холбоотой. Дэлхийн тэнхлэгээ эргэх хөдөлгөөнтэй холбоотой, сар дэлхийг тойрч эргэдэг, Сарыг харж буй би дэлхийн аль талд байгаа вэ гэдэг чухал гэх мэт - Битүүний шөнө сар хаана байрлаж байсан бэ? Нар дэлхий хоёрын дунд гэх зэргээр зургийг ажиглана, хараад тайлбарлана, бодно. 	
2. Хэрэглэх	 Улбар шар тойрог доторх сарны харагдаж буй тал нар руу харсан гэдгийг ойлгож, сар гэрэлтэхгүй. Нарны гэрэлд сар харагдаж буйг тооцоолно.	
3. Үнэлэх	Сарны бусад хэлбэрийг ажиглаад, нэрийг нь бичээрэй.  Тал сар, хавирган сар, бүтэн буюу тэргэл сарыг нэрлэж чадна. Гэтэл шинэ сар гэдэг нь харагдах байдлаараа бус сар эхэлж буйтай холбоотой болохыг ихэнх тал сар буюу арвидах, хорогдох сарыг хэрхэн нэрлэх талаас нь эргэцүүлж дүгнэнэ. Зарим нь 9-нөөс 15 ны хооронд харагдах гээд өдрөөр бичиж болно.	
4. Бүтээх	 Сарны хэлбэрийг зурсан байх нь чухал	

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Алтан гадас одны байрлал-1**


Анги: **5 дугаар анги**

1. Хэрэглэх	Долоон бурхан одны байрлалыг өөрийн мэдэхээр зурна.	
2. Задлан шинжлэх	Долоон бурхан одыг олох туршилт хийж, өөрийн зурсантай харьцуулна. Хэрэв байрлалаас шалтгаалан өөр өөр хэлбэрээр зурсан бол шалтгааныг тайлбарлана.	
3. Задлан шинжлэх	Алтан гадас од, долоон бурхан одны уялдаа холбоо, зүй тогтлыг илрүүлэх, тогтмол давтамжтай ажиглая, харж судлах зэргээр асуултад хариулах явцдаа шалтгааныг тайлбарлана.	
4. Бүтээх	Мэдээлэл цуглуулна Ажиглалт хийнэ гэх мэт аргаа боловсруулах, төлөвлөх	

Бүлэг сэдэв: **Одот тэнгэр**

Дэд сэдэв: **Алтан гадас одны байрлал-2**

Анги: **5 дугаар анги**

1. Хэрэглэх	Долоон бурхан одны байрлал болон бусад одны ордыг хэв ашиглан харах турших	
2. Хэрэглэх	Долоон бурхан одыг олох туршилт хийх, долоон бурхан од улирал бүр өөр өөр байрлалтай харагддаг болохыг илрүүлэх, мэдэх	
3. Үнэлэх	Долоон бурхан одны байрлал бүрийг ажиглаж, улирал бүр өөр өөр харагддагийг мэдэж авснаар алтан гадас одыг хэзээ ч харж, зааж чаддаг болно. Энэ нь алтан гадас одоор хойд зүгийг олж сурах, амьдралд хэрэглээ болгох гэдгийг тайлбарлана.	